



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 06 сарын 20 өдөр

Дугаар А/155

Улаанбаатар хот

Тооллогын комисс байгуулах тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.1, 71.1.2, 71.1.3 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Яамны 2017 оны эхний хагас жилийн эд хөрөнгийн тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Б.Пүрэвсүрэн, Эдийн засаг, санхүүгийн хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Т.Гансүх, Аж ахуйн менежер
Гишүүд:	Б.Долгорсүрэн, Эмнэлгийн тусламжийн газрын мэргэжилтэн О.Гантулга, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод, аудитын газрын мэргэжилтэн Д.Мөнхцэцэг, Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн мэргэжилтэн Б.Нинжбадгар, Нийгмийн эрүүл мэндийн газрын мэргэжилтэн П.Энхболор, Нярав

2. Яамны эд хөрөнгийн тооллогыг 2017 оны 06 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн 2017 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор багтаан үнэн зөв, чанартай явуулж, эд хөрөнгийн ангиллыг жагсаалтаар гарган эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, эмх цэгцийг сайжруулах арга хэмжээг авч, тооллогын нэгдсэн дүнг Төрийн өмчийн хороонд хүргүүлэхийг Тооллогын комисс /Б.Пүрэвсүрэн/-т даалгасугай.

3. Тооллогын комиссын гишүүдийн ажилласан хугацааны илүү цагийн хөлсийг тооцож олгохыг нягтлан бодогч /Б.Банзрагч/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ОЧИРБАТ

080618



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 06 сарын 16 өдөр

Дугаар А/1242

Улаанбаатар хот

Автомашин буцаан олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2016 оны 160 дугаар тогтоол, 2017 оны 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засгийн газрын 2016 оны 160 дугаар тогтоол, 2017 оны 07 дугаар тогтоолын дагуу өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрсэн зарим аймаг, сумдын хүн эмнэлэгт улсын нөөцөөс олгосон 36 автомашиныг улсын нөөцөд буцаан олгосугай.
2. Автомашиныг буцаан олгох арга хэмжээ авч ажиллахыг Хөрөнгө оруулалтын хэлтэс /Я.Болормаа/-т үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/-д даалгасугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

080775